



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг

Утас/Факс: 7046-36-12

И-мэйл: zavkhan@audit.gov.mn

ЗАВХАН АЙМГИЙН НӨМРӨГ
СУМЫН СОНГУУЛИЙН ХОРООНД

2024.08.28

№

448

танай

-ны №

-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр
хуульд заасан шаардлагад
нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох Хоролсүрэнгийн Батнасангийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Audit(D)Дүгнэлт/2024

0130.08.22


Дүгнэлт

Хоролсүрэнгийн Батнасангийн /РД:ИИ81012404/ Орон нутгийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Х.Батнасангийн мөрийн хөтөлбөр (6 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч Х.Батнасанд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

**ЗАВХАН АЙМГИЙН НӨМРӨГ СУМЫН 2-р ТОЙРОГТ БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
Х.БАТНАСАНГИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Эрхэм зорилго: Орон нутгийн иргэдийн нийтлэг эрх ашгийг эрхэмлэсэн хөгжлийн бодлогыг эрхэмлэе

Хөтөлбөрийн зорилго:

Нэг. Алсын хараа хөгжлийн бодлогын хүрээнд хүний хөгжлийн бодлого үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар иргэдийн амьдралын хэв маягт дэвшил өөрчлөлт гаргана.

Хоёр. Иргэд олон нийтийн хэрэгцээний судалгаа авч саналд тулгуурласан хөгжлийн бодлогоор баг сумаа хөгжүүлнэ.

Гурав. Ард иргэдийнхээ эрх ашиг хууль ёсны ашиг сонирхлыг дээдэлсэн төрийн ил тод шуурхай үйлчилгээг төлөвшүүлнэ.

НЭГ. ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГО

1.1. Эрүүл мэндийн бодлого

Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эмнэлгийн түслэмж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах чиглэлд.

1.1.1 Хүн амын эрүүл аж төрөх, эрүүл мэндээ хамгаалах зан үйлийг төлөвшүүлэн, хүүхэд залуучуудад эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийнхээ төлөө хүлээх гэр бүлийн хариуцлагыг дээшлүүлэх, ард иргэдийн дунд эмийн зохистой хэрэглээг сурталчлах ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтарч үе шаттайгаар зохион байгуулна.

1.1.2. "Эрүүл хүүхэд" аяныг өрнүүлж судалгаанд хамруулан шүдний явуулын кабинет ажиллуулж цэцэрлэг, сургуулийн хүүхдүүдийн шүд, амны хөндийг эрүүлжүүлэх ажлыг системтэйгээр зохион байгуулах үйл ажилгааг дэмжиж ирээдүйн эрүүл иргэнийг бэлтгэхэд анхаарч ажиллана.

1.2. Боловсролын бодлого

Боловсролын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлж, сургалтын таатай орчныг бүрдүүлэх чиглэлд.

1.2.1 Хүүхдэд ээлтэй сургалтын орчныг бүрдүүлж, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг 90 хувьд хүргэнэ.

1.2.2 Ерөнхий боловсролын сургуулийн дэргэд мэргэжлийн багш нарын чиглүүлэхтэй секц, дугуйлангуудыг тогтмол хичээллүүлж, урлаг спортын авьяасыг нээн илрүүлж, оюуны чадавхыг хөгжүүлэх үйлийг дэмжиж ажиллана.

1.2.3. Насан туршийн боловсролын төвийн сургалтын орчныг бэхжүүлж, үйл ажиллагааг нь өргөтгөн иргэдэд боловсрол нөхөн олгох тасралтгүй суралцах боломжийг хангаж ажиллана.

- 1.2.4. Хүүхдийг тодорхой зорилго чиглэлтэй амьдрах, эх орноо хайрлах үзэл баримтлалаар хүмүүжүүлж, нийгэмд зөв иргэн болж төлөвшүүлэхэд анхаарч хүүхэд хамгааллын хамтарсан багын үйл ажиллагаа, чанар хүртээмж, үйлчилгээг сайжруулна.
- 1.2.5. СӨБ болон ЕБС-ийн гүйцэтгэлийн үнэлгээний чанар үр дүнг ахиулах тал дээр сургалтын байгууллагуудтай хамтарч ажиллана.

1.3. Соёл, спорт, аялал жуулчлалын бодлого
Үндэсний урлаг, соёл, аялал жуулчлал, нийтийн биеийн тамир, спортын ажил, үйлчилгээний чанар, хүртээмжийг иргэд, олон нийтийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн сайжруулах.

- 1.3.1. Соёлын төвийн дэргэд хүүхэд залуучуудын дунд явагддаг урлагийн бүх төрлийн дугуйланд сумын сурагчдыг хамруулж авьяас чадвараа нээн хөгжүүлэх үйлд чиглүүлнэ.
- 1.3.2. Хүүхэд залуус хойч үеийнхэнд үндэсний өв уламжлалаа сэргээх өвлөн уламжлуулах төрөл бүрийг арга хэмжээг жил бүр тогтмол зохион байгуулж хэвшнэ.
- 1.3.3. Орон нутаг судлах музей, соёлын үнэт зүйл, өвийг хадгалж хамгаалах ажилд сумын иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 1.3.4. Номын сангаар үйлчлүүлэх номд дурлах соён гэгээрэх үйлд хүүхэд залуусыг татан оролцуулна.
- 1.3.5. Удмын сангаа хамгаалах угийн бичиг хөтлөх өрхийн тоог нэмэгдүүлэхэд уриалж ажиллана.
- 1.3.6. Залуучуудын байгууллагын санаачилгыг дэмжих, авьяас сонирхлыг хөгжүүлэх, чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэхэд зориулсан төрөл бүрийн клуб байгуулах санал санаачилгыг дэмжин ажиллана.

1.4. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлого
Нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар, хүрээмжийг сайжруулан, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх

- 1.4.1. Үйлдвэрлэл, өрхийн аж ахуй эрхлэх хүсэлтэй иргэдийг зээл хөтөлбөрт хамруулан өрхийн амьжиргааны түвшинг сайжруулхад гүүр болж ажиллана.
- 1.4.2. Удмын сангаа хамгаалах угийн бичиг хөтлөх өрхийн тоог нэмэгдүүлэхэд уриалж ажиллана.
- 1.4.3. Ахмадуудын чадамжид суурилсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж ажиллана.
- 1.4.4. Ахмад настныг нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах, тэдний амьдралын туршлага мэдлэг чадварыг залуу үеийнхэнд өвлүүлэх зорилгоор сумын ИТХ даргын дэргэд "Ахмад мэргэжилтнүүд"-ийн зөвлөлийг байгуулан зөвлөх үйлчилгээг баг болон салбар бүрд хэрэгжүүлэн ажиллана.

- 1.4.5. Start up гарааны бизнесийг хэрэгжилтийг нэмэгдүүлэх. (Start up гэдэг нь сум орон нутагт нэн тэргүүнд хэрэгтэй байгаа бизнесийг шинээр эхлэхийг хэлнэ.)

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

2.1. Хөдөө аж ахуйн бодлого

Мал аж ахуй, газар тариалангийн эрчимжүүлэлтийг нэмэгдүүлж, нэгжээс авах ашиг шимээр орон нутгийнхаа хэрэгцээний хангамжийг нэмэгдүүлнэ.

- 2.1.1. Газар тариалангийн хувийн жинг өсгөж, нэгж талбайгаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.
- 2.1.2. Шинэ хоршоо хөдөлгөөнийг дэмжих замаар хөдөөгийн иргэдийн хоршин аж ахуйгаа хөтлөх хамтын хөдөлмөрийг шинэ шатанд гаргана.
- 2.1.3. Малын гаралтай сүү цагаан идээ, ноос ноосон бүтээгдэхүүн, арьс шир, зөөлөн оёдол, мод модон бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах, бүс,аймагт зохион байгуулагддаг үзэсгэлэн худалдаанд оролцуулах ажлыг дэмжин ажиллаж нутгийн брэнд бүтээгдэхүүний тоо хэмжээг нэмэгдүүлэхэд анхаарна..
- 2.1.4. Мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах ажлыг тогтмолжуулж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг дээшлүүлэхэд мал эмнэлэгийн салбартай хамтарч ажиллана.
- 2.1.5. Бэлчээрийг хортон мэрэгчдээс хамгаалах арга хэмжээг дэмжиж жил бүрийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулж хамтарч ажиллана.
- 2.1.6. Ойг хөнөөлт хортон шавжаас хамгаалах, нөхөн сэргээх ажилд санаачилга гаргаж холбогдох байгууллагад нь уламжилж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.
- 2.1.7. Байгалийн үзэсгэлэнтэй газрыг ашиглан амралт сувиллын үйл ажиллагааг эрхлэх сонирхолтой иргэдэд сургалт зохион байгуулж аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээ авна.
- 2.1.8. Монгол Улсын төсвийн тухай хуулийн 58.3, 58.4-д зааснаар сум дүүрэг хөгжүүлэх сангаас ногоон байгууламжийг бий болгох цэцэрлэгт хүрээлэн байгуулах сэргээн засах ажлын зардлыг жил бүр төсөвт тусган хэрэгжилтийг хангуулан ажиллана.

2.2. Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний бодлого

Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тоо хэмжээг нэмэгдүүлж, худалдаа, үйлчилгээний соёлч чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх.

- 2.2.1. Бараа бүтээгдэхүүнээ зах зээлийн эргэлтэд оруулах иргэн аж ахуй нэгж, оёдлын цехүүдийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана.
- 2.2.2. Сүү сүүн бүтээгдэхүүн, ноос ноолуур, арьс шир зэрэг МАА-н гаралтай бүтээгдэхүүн боловсруулах жижиг, дунд үйлдвэрийг байгуулах санал санаачилгыг дэмжинэ.

2.2.3. Суманд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжиж сурталчлан таниулах, үзэсгэлэн худалдаануудад сонирхсон иргэдийг жил бүр тогтмол хамруулна.

2.2.4. Эрүүл ахуйн шаардлага хангасан, орчин үеийн тохилго ахуй үйлчилгээ, худалдааны цогцолбор төв байгуулах иргэдийн саналыг дэмжин ажиллана.

2.3. Дэд бүтэц

Дэд бүтцийн төлөвлөлтийг сайжруулж, хот тосгоноо хөгжүүлэх.

2.3.1. Алсын хараа 2050 хөгжлийн бодлогын хүрээнд сумын хөгжлийг шинэ шатанд гаргах талаар санаачилга гаргаж "Миний гоё сум" хөдөлгөөн өрнүүлнэ. Үүнд: Аж ахуйн нэгж байгууллагын хаяг, рекламьг шинэчлэх, гадна орчиндоо гэрэлтүүлэгтэй болгох, айл өрхийн хашаа, барилга байгууламжуудын өнгө үзэмжийг сайжруулахад анхаарна.

2.3.3. Хүн амын ундны усны эрүүл ахуйг хангах зорилгоор шинжилгээнд хамруулж стандартын шаардлагад нийцүүлэхэд мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана.

2.3.4. Сумын нийтийн халуун усны газрын үйл ажиллагааг тогтмолжуулах

2.3.5. Газар зохион байгуулалтын төлөвлөлт, газар ашиглалтыг сайжруулж, газрын зөрчлийг арилгах ажлыг төлөвлөгөөтэйгөөр зохион байгуулж мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллана.

2.4. Төсөв санхүүгийн чиглэлээр

Сумын төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж, төсвийн өргүй ажиллах боломжид анхаарах.

2.4.1. Орон нутгийн болон тусгай шилжүүлгийн байгууллагуудын батлагдсан төсвийг зориулалтын дагуу хэмнэлттэй зарцуулж, байгаа эсэхэд хяналт тавьж төсвийн үргүй зардал гаргуулахгүй байх тал дээр анхаарч ажиллана.

2.4.2. Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх хөрөнгө оруулалтын ажлуудын чанар гүйцэтгэлд хяналт тавина.

2.5. Байгаль орчны талаар хэрэгжүүлэх бодлого

Байгалийн баялгийг ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, хөрс, ус, агаарын бохирдлоос сэргийлэх ажилд иргэдийн тавих хяналт, оролцоог нэмэгдүүлэх.

2.5.1. Байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглуулах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг хуулийн дагуу хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавина.

2.5.2. Байгаль орчныг эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, хяналт шалгалтыг тогтмолжуулан хууль бус үйлдлүүдийг таслан зогсоох арга хэмжээнд идэвх санаачилгатай ажиллана.

2.5.3. Бүх нийтээр мод тарих ажлыг жил тутам зохион байгуулж, төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд иргэн, ААНБ-ийг идэвхтэй оролцуулах талаар анхаарч манлайлж оролцоно.

2.5.4. Хэт нимгэн хэрэглээнээс гарсан нийлэг уутыг халж цаасан болон даавуун уут хэрэглээнд нэвтрүүлэх санал санаачилгыг дэмжинэ.

2.5.5 Нэг удаагийн хэрэглээний эд материалаас татгалзаж байгаль экологид ээлтэй өрхийн эдийн засагт хэмнэлттэй хэрэглээг бий болгоход санаачилга гарган ажиллана.

ГУРАВ. НУТГИЙН ЗАХИРГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ

3.1. Нутгийн захиргааны ажил үйлчилгээ

Нутгийн захиргааны ажил үйлчилгээг ил тод, нээлттэй, шуурхай, хариуцлагатай болгож, төр, иргэний харилцан итгэлцлийг бэхжүүлэх

3.1.1. Төрийн үйлчилгээний ил тод, шуурхай байдлыг хангаж, төрийн албан хаагчийн ажлын хариуцлага ёс зүйд анхаарч ажиллана.

3.1.2. Төрийн албан хаагчийг гадаад, дотоодын хэрэгцээт сургалтад хамруулах, мэргэшүүлэх, ажиллах нөхцөлийг сайжруулна.

3.1.3. Цахим "Иргэний танхим"-ийн үйл ажиллагааг бие болгон иргэдийн санал бодлыг байнга сонсож төрийн үйлчилгээ, бодлого төлөвлөлтөд тусгаж ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

3.1.4. Мэдээлэл технологийг ашиглан "Цахим засаглал" хөтөлбөрийг хэрэгжүүлж, ИТХ-ын сайтын үйл ажиллагааг сайжруулна.

3.1.5. Төрийн албан хаагчдын ажлын цаг баримтлах соёлыг сайжруулна.

3.2. Хүний эрхийг хангах, хууль, эрх зүйн ажил үйлчилгээ

Хүний эрхийг хангах, хууль, эрх зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх ажил үйлчилгээний үр нөлөөг сайжруулах.

3.2.1. Хууль, эрх зүй, харилцаа, хандлага, гэр бүл ба хүүхдийн хүмүүжил, жендерийн эрх тэгш байдлыг хангах талаар албан бус сургалт, сурталчилгааны ажлыг тогтмолжуулан, иргэдийн эрх зүйн боловсролыг сайжруулахад НТБ төвтэй хамтарч ажиллана.

3.2.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг сахиулах ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

3.2.3. Архидан согтуурахаас зайлсхийх төрийн бодлогын орон нутаг дахь хэрэгжилтийг хангах зорилгоор "Архидалттай тэмцэх" хөдөлгөөнийг иргэдийн саналд тулгуурлан боловсруулж хэрэгжүүлнэ.

3.2.4. Согтууруулах ундаагаар үйлчилдэг ААНБ-ын үйл ажиллагаанд хяналт тавьж, өсвөр үеийнхний ёс суртахууны боловсролд анхаарч, зөрчил дутагдлыг бууруулахад мэргэжлийн хүмүүстэй хамтарч ажиллана.

- 3.2.5. Хүүхдийг буруу зуршилд автахаас урьдчилан сэргийлэх, болзошгүй осол, гэмт үйлдлээс хамгаалахад чиглэсэн арга хэмжээг мэргэжлийн байгууллагатай хамтарч зохион байгуулж хэвшүүлнэ. Мөн "Зөв Монгол хүн" төлөвшүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагуудын ажлын уялдаа холбоог зангидаж ажиллана.
- 3.2.6. Хөдөлгөөнт эргүүлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, цагдаагийн байгууллагын үйлчилгээний шуурхай байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 3.2.7. Иргэд болон авлигатай тэмцэх төрийн бус байгууллагатай хамтран авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын үр нөлөөг дээшлүүлж, авлигагүй орчин бүрдүүлэх тал дээр анхаарна.

3.3. Гамшгаас хамгаалах бодлого

- 3.3.1. Гамшгаас хамгаалах санг жил бүрийн төсөвт тусган, ой хээрийн түймэр, үер ус, халдварт өвчин, зуд, барилга байгууламжийн гал түймэр зэрэг болзошгүй аюулаас сэргийлэх, аюулыг бууруулах, бэлэн байдлыг хангахад анхаарч ажиллана.
- 3.3.2. Гамшиг осолтой тэмцэх чадавхыг нэмэгдүүлэх, бэлэн байдлыг хангах эрсдэлийг бууруулахад ажлын явц үр дүнд хяналт тавьж ажиллана.

ХИЧЭЭЛ ЗҮТГЭЛЭЭР ХӨГЖИН ДЭВЖИЦГЭЭ

Мөрийн хөтөбөр боловсруулсан бие даагч *Х.Батнасан* Х.Батнасан

